



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2026 оны 02 сарын 21 өдөр

Дугаар А/21

Баян-Өндөр сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг заалт, Засгийн газрын 2025 оны "Хяналт шалгалтын 2026 оны төлөвлөгөө батлах тухай" 184 дүгээр тогтоол, Аймгийн Засаг даргын 2026 оны А/78 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн салбарт хэрэгжихээр тусгагдсан төсөл хөтөлбөрийн жагсаалтын "Хүнд ээлтэй амьдрах орчин бий болгоход орчны агаар, ундны ус, хөрс, халдваргүйтгэлийн ариутгалын бодисын чанар, орчны эд зүйлсийн гадаргууд эрүүл зүйн нян судлал, хими, хор судлалын шинжилгээг нэмэгдүүлэн нотолгоонд суурилсан арга хэмжээ авч хэрэгжүүлэх зардал"-д Хяналт шалгалтын хэлтсээс эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын 4 чиглэлээр удирдамжтайгаар хийгдэх урьдчилан сэргийлэх шинжилгээт хяналт шалгалтаар арчдас, агаар, хөрс, ариун материал, ундны ус, хоол, хүнсний бүтээгдэхүүн, халдваргүйтгэлийн бодисын идэвхи тодорхойлох шинжилгээ хийлгэхэд шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.
2. Шинжилгээний нийт санхүүжилт болох 26,421,000 (Хорин зургаан сая дөрвөн зуун хорин нэгэн мянга)-н төгрөгийг нэмэлт санхүүжилтийн данснаас гаргахыг Салбарын санхүү бүртгэл мэдээлэл, нягтлан бодохын ажилтан (Н.Чулуун-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.
3. Батлагдсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Хяналт шалгалтын хэлтсийн дарга, улсын ахлах байцаагч (Д.Оюунтунгалаг) -т даалгасугай.

ДАРГА



Б.МӨНХЦЭЦЭГ

Эрүүл мэндийн газрын даргын 2026 оны
02 сарын 28-ний өдрийн 121-тоот
тушаалын хавсралт



Урьдчилан сэргийлэх шинжилгээт хяналт шалгалтад хамрагдах объектуудад хийгдэх шинжилгээний зардлын тооцоо

№	Зардлын төрөл	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
1. Орчны агаар, ундны ус, хөрсөнд эрүүл зүйн нян судлал, хими хор судлалын чиглэлээр хийгдэх шинжилгээ				
1.	Усны шинжилгээ	99,500	20	1,990,000
2.	Хөрсний шинжилгээ	35,000	20	700,000
3.	• Арчдас	8,000	100	800,000
4.	Шинжилгээний авах шатахууны зардал	2,690	816,35	2,196,000
5.	Шинжилгээний маягт хэвлэх зардал	2,445	676	1,656,000
6.	Бичиг хэргийн материалын зардал	16,000	40	640,000
Дүн				7,982,000
2. Хоол хүнсний бүтээгдэхүүн, ундны ус, гадаргуугийн эрүүл зүйн нян судлал, хими хор судлалын шинжилгээний дээж авах, сорьц шинжлүүлэх				
1.	Усны шинжилгээ	99,500	3	298,500
2.	Хоолны шинжилгээ	79,500	9	715,500
3.	Арчдас	8,000	150	1,200,000
4.	Шинжилгээний авах шатахууны зардал	2,690	800	2,152,000
5.	Шинжилгээний маягт хэвлэх зардал	2,445	676	1,656,000
6.	Бичиг хэргийн материалын зардал	16,000	45	720,000
Дүн				6,742,000
3. Эрүүл мэнд, боловсролын байгууллагуудын орчны агаар, ариун материал, халдваргүйтгэлийн бодисын идэвхит чанар, эмчилгээний хоол, гадаргуугийн арчдасны нян				

судлал, хими хор судлалын шинжилгээний дээж авах, сорьц авах				
1.	Гадаргуугийн арчдас	8,000	500	4,000,000
2.	Ариун материал	7,000	40	280,000
3.	Нян устгах чадвар	20	11	220,000
4.	Эмчилгээний хоол	79,500	22	1,749,000
5.	Агаар	30,000	36	1,080,000
6.	Шинжилгээний авах шатахууны зардал	2,690	800	2,152,000
7.	Шинжилгээний маягт хэвлэх зардал	2,445	676	1,656,000
8.	Бичиг хэргийн материалын зардал	16,000	35	560,000
Дүн				11,697,000
Нийт дүн				26,421,000